

# ЖЕНДЭР БОЛОН ОРХИГДСОН БҮЛГҮҮДЭД ЧИГЛЭСЭН ЭМЗЭГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛ







БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



GREEN  
CLIMATE  
FUND



# ЖЕНДЭР БОЛОН ОРХИГДСОН БҮЛГҮҮДЭД ЧИГЛЭСЭН ЭМЗЭГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛ

---

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг  
боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх төсөл

УЛААНБААТАР ХОТ  
2021

## ГАРЧИГ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	3
2. ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ .....	3
3. БАРИМТЛАХ ЗАРЧИМ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР .....	4
4. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ .....	4
5. ҮР ДҮНГ АШИГЛАХ ЗААВАР .....	10
6. АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	10

## 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчин аялал жуулчлалын яам болон Нэгдсэн үндэсний байгууллагын байгаль орчны хөтөлбөрөөс Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавх бэхжүүлэх” төслийн хүрээнд жендер болон орхигдсон бүлгүүдэд чиглэсэн уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хэмжээнд эмзэг байдлын үнэлгээг хийхэд энэхүү үнэлгээний индекс тооцох аргачлалыг ашигласан.

Эмзэг байдлыг байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуй гэх мэт салбар бүрээр авч үздэг бөгөөд эмзэг байдлыг үнэлэх тухайн зорилгоосоо хамаараад үндэсний түвшинд, орон нутгийн түвшинд, дүүргийн түвшинд, эсвэл аль нэг салбарын түвшинд гэх мэт янз бүрээр үнэлдэг. Түүнчлэн хамрах хүрээ зорилгоосоо шалтгаалсан байгаль орчны эмзэг байдал, нийгмийн эмзэг байдал, эдийн засгийн эмзэг байдал гэх мэт төрөл бүрийн индекс үзүүлэлтээр эмзэг байдлыг хэмжиж байна.

## 2. ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

Эмзэг байдлыг үнэлэх тооцооллын хувьд дараах гурван томъёогоор бодож, эмзэг байдлыг үнэлнэ.

**Эмзэг байдал = (Өртөх байдал+Мэдрэмтгий байдал) - Дасан зохицох чадавх**

*Өртөх байдал, мэдрэмтгий байдал* хоёр нь эмзэг байдлыг нэмэгдүүлж байхад дасан зохицох чадвар нь эмзэг байдлыг бууруулах буюу уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхтай байгааг илтгэх үзүүлэлт юм.

Тооцооллын аргачлалын хувьд эдгээр гурван бүтээгдэхүүн тус бүрд сонгосон шалгуур үзүүлэлтүүдийг стандарт хэлбэрт оруулан, үзүүлэлт бүрийн утга 0-1 хүртэл хооронд байхаар индексжүүлсэн. Индекс 1-ийн утга хамгийн эмзэг байдлыг илэрхийлэх бол, 0-рүү тэмүүлэх тусам эмзэг байдал буурна. Индексжүүлэхдээ шалгуур үзүүлэлтийн шинж чанараас хамааран 2 бүлэгт авч үзэн тооцсон. Үүнд:

**Эерэг үзүүлэлт:** тухайн үзүүлэлтийг сайжруулахын тулд өсгөж, нэмэгдүүлэхийг зорилго болгохыг хэлнэ. Эерэг үзүүлэлтийн индексийг дараах ерөнхий томъёогоор тооцсон:

$$\text{Индекс} = 1 - \frac{\text{Бодит утга} - \text{Хамгийн доод утга}}{\text{Хамгийн дээд утга} - \text{Хамгийн доод утга}}$$

**Сөрөг үзүүлэлт:** тухайн үзүүлэлтийг сайжруулахын тулд бууруулж багасгахыг зорилго болгохыг хэлнэ. Сөрөг үзүүлэлтийг дараах томъёогоор тооцсон:

$$\text{Индекс} = \frac{\text{Бодит утга} - \text{Хамгийн доод утга}}{\text{Хамгийн дээд утга} - \text{Хамгийн доод утга}}$$

Сонгосон шалгуур үзүүлэлт бүрийн индексийг тооцсоны дараа индексүүдийн геометр дунджийг олж бүрэлдэхүүн тус бүрийн индексийг тооцсон.

### 3. БАРИМТЛАХ ЗАРЧИМ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Индекс тооцохдоо дараах зарчмыг баримтлана. Үүнд:

- 3.1.1. Үзүүлэлтүүд өөр хоорондоо холбоо хамааралтай байх;
- 3.1.2. Шинжлэх ухааны үндэслэл бүхий нэгдмэл арга зүйтэй байх;
- 3.1.3. Мэдээллийн эх үүсвэр тодорхой, мэдээлэл нь тогтмол, үнэн бодитой байх;
- 3.1.4. Хэмжих боломжтой, тодорхой үзүүлэлтийг сонгосон байх;
- 3.1.5. Үндэсний болон орон нутгийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байх;

Мэдээлэл цуглуулах арга

Эмзэг байдлын үнэлгээний бүрэлдэхүүнүүдийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг анхдагч болон хоёрдогч тоон мэдээлэлд үндэслэн гаргана.

Анхдагч мэдээллийг 21 аймаг болон Улаанбаатар хот дахь экспертүүдтэй ганцаарчлан уулзах, утсаар ярилцлага авах болон онлайн асуулгаар цуглуулах боломжтой.

Хоёрдогч мэдээлэлд Үндэсний статистикийн хороо /ҮСХ/ -ийн нээлттэй мэдээллийн санд байгаа дата мэдээллээс гадна цаг уур, гамшиг, онцгой байдлын талаарх мэдээллүүдийг хариуцсан байгууллага, агентлагуудад хандан авах гэх мэт.

### 4. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Баримт бичиг, судлагдсан байдлын судалгаа, оролцогч талуудын хэлэлцүүлэг, ганцаарчилсан ярилцлагууд болон дата, мэдээллийн боломжит байдалд үндэслэн эдгээр гурван бүтээгдэхүүн тус бүрийн шалгуур үзүүлэлтээр дараах мэдээллүүдийг сонгоно.

Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Бүрэлдэхүүн	Шалгуур үзүүлэлтүүд
Өртөх байдал	Ган
	Зуд
	Газрын эвдрэл гэмтэл
Мэдрэмтгий байдал	Ядуурлын түвшин
	Ажилгүйдлийн түвшин
	Гамшигт өртсөн хүмүүсийн эзлэх хувь
	Боловсролд хамрагдалт
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь
	Шилжилт хөдөлгөөн
Дасан зохицох чадавх	Нийгмийн даатгал төлдөг хүмүүсийн эзлэх хувь
	Интернэт хэрэглэгчдийн хувь
	Үүрэн утас хэрэглэгчдийн хувь
	Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх иргэдийн, ойлголт, мэдлэг, хандлага
	Гамшиг, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжиж буй байдал
	Гамшгийн менежментийн хөтөлбөртэй эсэх
	Эрүүл мэндийн байгууллагын тоо

#### 4.1. Өртөх байдал

Өртөх байдлын шалгуур үзүүлэлтүүдийг нийслэл болон 21 аймгийн хэмжээнд ган зудын давтамж, газрын эвдрэл гэмтлийн хэмжээгээр сонгож авлаа. Өртөх байдлын индексийг тооцохдоо Ус цаг уур орчны шинжилгээний хүрээлэнгээс Ган зудын давтамжийн мэдээллийг аймаг тус бүрээр, Газрын мэдээллийн нэгдсэн сангийн газрын эвдрэл гэмтлийн мэдээллийг аймаг тус бүрээр гаргуулж хэвшихийг зөвлөмж болгон хүргүүлж байна.

#### 4.2. Мэдрэмтгий байдал

Мэдрэмтгий байдлын шалгуур үзүүлэлтүүдийг нийслэл болон 21 аймгийн хэмжээнд нас, хүйсийн бүлгээр ангилж тооцно.

##### \* Хамран сургалтын бохир жин

Тооцох арга зүй: Нас харгалзалгүйгээр тодорхой түвшний нийт суралцагчдын тоог тухайн хичээлийн жилд тэр түвшинд суралцвал зохих насны нийт хүүхдэд эзлэх хувиар илэрхийлсэн үзүүлэлт юм.

Мэдээллийн эх үүсвэр: БШУЯ-ны суурь боловсролын байгууллагын тайлан мэдээгээр тооцно

Давтамж: Жилээр гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

##### \* Дундаж наслалтын индексийг тооцохдоо

Тооцох арга зүй: Насжилтын хүснэгт ашиглан тооцсон дундаж наслалтаас бодно.

Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний Статистикийн хорооны мэдээлэл

Мэдээллийн давтамж: Жилээр гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

##### \* Малчин өрхийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Хөдөө аж ахуйн салбарын статистик үзүүлэлтүүдийг тооцох аргачлал.

Мэдээллийн эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны мэдээлэл

Мэдээллийн давтамж: Жилээр гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

##### \* Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал.

Мэдээллийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Нийгмийн зарим үзүүлэлтүүд

Мэдээллийн давтамж: Жилээр гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

##### \* Ганц бие өрх толгойлсон өрхийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Өрх тэргүүлдэг гэсэн нөхцөл хангагдсан бүх хүнийг насны хязгаар харгалзахгүйгээр өрх толгойлсон эх /эцэг/-т хамруулна. Дээрхээс бусад шалтгаанаар тусдаа амьдарч байгаа эхнэр нөхрийг өрх толгойлсон эх /эцэг/-т хамруулахгүй.

Мэдээллийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Нийгмийн зарим үзүүлэлтүүд

Мэдээллийн давтамж: Жилээр гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

#### \* Шилжилт хөдөлгөөн

Тооцох арга зүй: Тухайн улс, орны хилийн хүрээн доторх засаг захиргааны нэгж хоорондох, түүнчлэн байршлын хувьд (хот, хөдөө) явагдах хүн амын суурьшлын өөрчлөлтөөр тодорхойлогдоно. Шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлт нь шилжин явагчдын тоо болно.

Мэдээллийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Хүн амын шилжих хөдөлгөөний жилийн эцсийн тайлан, ХА-2

Мэдээллийн давтамж: Жилээр гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

#### \* Ядуурал

Тооцох арга зүй: Ядуурлын хамралтын хүрээний индекс ( $\alpha=0$ ) буюу ядуурлын түвшин нь нийт хүн амд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувийг харуулна.

Мэдээллийн эх сурвалж: Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

Мэдээллийн давтамж: Бусад /бичих/

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

#### \* Ажилгүйдэл

Тооцох арга зүй: Хөдөлмөрийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийн мэдээллийн эх үүсвэр нь Ажиллах хүчний судалгаа. Судалгааны үр дүнг улс, аймаг, нийслэлийн түвшинд насны бүлэг, хүйс, эдийн засгийн ангилал, хөдөлмөр эрхлэлтийн статус гэх мэт дэд ангиллаар тооцоход цөөн тооны зөрүү гардаг. Учир нь судалгааны үр дүнг SPSS программаас жин тооцон, үр дүнг бутархай тооноос бүхэл оронтой тоо руу шилжүүлэн авдаг.

Мэдээллийн эх сурвалж: Ажиллах хүчний судалгаа

Мэдээллийн давтамж: Улирал, жилээр

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

#### \* Албан бус салбарт (хөдөө аж ахуйн салбар орсон) ажилдаг хүмүүсийн эзэлдэг хувь

Тооцох арга зүй: Албан бус хөдөлмөр эрхлэгч гэж албан бус ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Нийт ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувиар илэрхийлнэ. Энэ үзүүлэлтийг хөдөө аж ахуйн бус салбарт болон нийт ажиллагчдаар тооцно.

Мэдээллийн эх сурвалж: Ажиллах хүчний судалгаа

Мэдээллийн давтамж: Жилээр гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

#### \* Гамшигт өртөж нас барсан хүмүүсийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд гамшигийн улмаас болж нас барсан хүний нийт хүн амын тоонд эзлэх хувиар тооцно.

Мэдээллийн эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газар

Мэдээллийн давтамж: Бусад /бичих/

Мэдээллийн задаргаа: Улсын хэмжээнд гаргана



Хүснэгт 2. Мэдрэмтгий байдлын индекс 2020 оны байдлаар

	Хамран сургалтын бохир жин	Дундаж наслалтын индекс	Малчин өрхийн эзлэх хувь	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь	18 хүртэл насны ганц бие өрх толгойлсон өрхийн эзлэх хувь	Ганцаар амьдардаг ахмад өрх	Шилжилт хөдөлгөөн	Ядуурал	Ажилгүйдэл	Албан бус хөдөө аж ахуйн салбарт ажилдаг хүмүүсийн эзэлдэг хувь	Гамшигт өртөж нас барсан хүмүүсийн эзлэх хувь	Ерөнхий индекс
Завхан	0.035	0.320	0.408	0.049	0.053	0.074	0.034	0.366	0.067	0.848	0.0001	0.063
Булган	0.075	0.282	0.436	0.039	0.049	0.051	0.025	0.341	0.078	0.867	0.0001	0.063
Баянхонгор	0.039	0.266	0.443	0.040	0.090	0.061	0.021	0.342	0.062	0.772	0.0001	0.058
Говь-алтай	0.045	0.228	0.427	0.032	0.062	0.064	0.028	0.442	0.074	0.860	0.0001	0.058
Хөвсгөл	0.034	0.239	0.410	0.041	0.086	0.064	0.017	0.272	0.072	0.808	0.0001	0.057
Архангай	0.044	0.214	0.532	0.039	0.046	0.057	0.024	0.379	0.048	0.829	0.0001	0.056
Дундговь	0.027	0.258	0.461	0.043	0.076	0.060	0.030	0.223	0.051	0.945	0.0001	0.055
Төв	0.049	0.228	0.380	0.033	0.052	0.057	0.039	0.189	0.038	0.799	0.0001	0.054
Говь-Сүмбэр	0.027	0.247	0.131	0.035	0.089	0.040	0.040	0.522	0.080	0.811	0.0001	0.053
Өвөрхангай	0.038	0.281	0.451	0.035	0.057	0.051	0.019	0.376	0.053	0.802	0.0001	0.052
Ховд	0.028	0.228	0.342	0.032	0.049	0.056	0.021	0.389	0.068	0.633	0.0001	0.052
Хэнтий	0.010	0.238	0.304	0.041	0.078	0.055	0.026	0.409	0.079	0.801	0.0001	0.052
Сэлэнгэ	0.050	0.234	0.149	0.037	0.068	0.030	0.027	0.352	0.051	0.690	0.0001	0.051
Дорноговь	0.035	0.218	0.201	0.031	0.079	0.038	0.024	0.233	0.060	0.586	0.0001	0.046
Өмнөговь	0.035	0.253	0.276	0.022	0.085	0.044	0.020	0.136	0.067	0.761	0.0001	0.046
Баян-Өлгий	0.064	0.273	0.384	0.043	0.049	0.011	0.014	0.294	0.107	0.085	0.0001	0.041
Увс	0.043	0.220	0.399	0.002	0.036	0.074	0.006	0.269	0.072	0.896	0.0001	0.036
Дорнод	0.000	0.242	0.190	0.049	0.081	0.037	0.025	0.420	0.108	0.645	0.0001	0.022
Сүхбаатар	0.000	0.206	0.413	0.040	0.049	0.046	0.019	0.386	0.070	0.842	0.0000	0.020
Дархан-Уул	0.000	0.272	0.040	0.030	0.063	0.035	0.030	0.331	0.087	0.313	0.0001	0.016
Орхон	0.000	0.212	0.031	0.031	0.069	0.023	0.028	0.243	0.106	0.183	0.0000	0.012
Улаанбаатар	0.000	0.293	0.005	0.332	0.056	0.014	0.034	0.254	0.050	0.010	0.0000	0.010
Улс	0.054	0.269	0.186	0.030	0.060	0.034	0.018	0.290	0.064	0.590	0.0004	0.054

### 4.3. Дасан зохицох байдал

Дасан зохицох байдлын шалгуур үзүүлэлтүүдийг нийслэл болон 21 аймгийн хэмжээнд тооцно.

#### \* Эрүүл мэндийн байгууллагын тоо

Тооцох арга зүй: Эрүүл мэндийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал (ҮСХ-ны даргын 2009 оны 11 сарын 18-ны өдрийн 01/151 тоот тушаал).

Мэдээллийн эх сурвалж: Эрүүл мэндийн яам

Мэдээллийн давтамж: Жилээр гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

#### \* Нэг их эмчид ноогдох хүний тоо

Тооцох арга зүй: Тухайн жилийн дундаж хүн амын тоог нийт их эмчийн тоонд хувааж тооцно. Эрүүл мэндийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал (ҮСХ-ны даргын 2009 оны 11 сарын 18-ны өдрийн 01/151 тоот тушаал).

Мэдээллийн эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Мэдээллийн давтамж: Жилээр гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

#### \* Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо

Тодорхойлолт: Нийгмийн даатгалын албан болон сайн дурын бүх төрлөөр даатгуулсан хүмүүсийн эзлэх хувиар илэрхийлнэ.

Мэдээллийн эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Мэдээллийн давтамж: Жилээр гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

#### \* Цахилгаан эх үүсвэрт холбогдсон өрхийн тоо

Тооцох арга зүй: 10 жил тутамд Хүн ам, орон сууцны тооллого /ХАОСТ/-ын дүнгээр цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрхийн тоог харуулна.

Мэдээллийн эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Хүн ам орон сууцны тооллого

Мэдээллийн давтамж: 10 жил тутамд гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

#### \* Гар утас хэрэглэгчдийн тоо

Тооцох арга зүй: Үүрэн технологид суурилсан, нийтийн телефон (үүрэн холбооны оператор) холбогдсон авсаархан, зөөврийн гар утас хэрэглэгчийг үүрэн утас хэрэглэгч гэнэ. Тухайн хүн өөрийн гэсэн үүрэн утас болон үүрэн утасны дугаартай бол гар утас хэрэглэгч гэж үзнэ. Харин дугаартай боловч утасгүй, утастай боловч дугааргүй тохиолдолд гар утасгүй гэж үзнэ.

Мэдээллийн эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Хүн ам орон сууцны тооллого

Мэдээллийн давтамж: 10 жил тутамд гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

**\* Интернэт хэрэглэгчдийн тоо**

Тооцох арга зүй: Телефон утас болон түрээсийн шугам, өндөр хурдны хэрэглэгчдийн тоон шугам буюу ДиЭсЭл (DSL), ЭйДиЭсЭл (ADSL), байнгын гарцтай, өндөр хурдны кабел модем, шилэн кабел хэрэглэгчийг интернэтийн байнгын хэрэглэгч гэнэ.

Мэдээллийн эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Хүн ам орон сууцны тооллого

Мэдээллийн давтамж: 10 жил тутамд гаргана

Мэдээллийн задаргаа: Улс, аймгийн түвшинд гаргана

Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Эерэг / Сөрөг	Дээд утга	Доод утга
1	Эрүүл мэндийн байгууллагын тоо	Тоо	+	0	1
2	Нэг их эмчид ноогдох хүний тоо	Тоо	-	0	1
3	Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо	Тоо	+	0	1
4	Цахилгаан эх үүсвэрт холбогдсон өрхийн тоо	Тоо	+	0	1
5	Гар утас хэрэглэгчдийн тоо	Тоо	+	0	1
6	Интернэт хэрэглэгчдийн тоо	Тоо	+	0	1

## 5. ҮР ДҮНГ АШИГЛАХ ЗААВАР

Жендэр болон орхигдсон бүлгийн эмзэг байдлын индекс нь орон нутгийн болон үндэсний хэмжээнд бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад уур амьсгалын өөрчлөлтөд тухайн орон нутаг болон үндэсний хэмжээнд ямар бүлгүүд эмзэг байгааг тодруулах боломжийг олгоно.

Энэхүү индексийг үндэсний түвшинд, бүс, аймаг, сумын түвшинд лавлагаа болгон ашиглана.

Индекс нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдыг хаана эрүүл, аюулгүй байдал илүү их алдагдаж, хаана аль бүлгийн, ямар хүйсийн хүмүүс уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж эрүүл мэнд амь нас, тав тухтай амьдрах нөхцөл байдал нь эмзэг өндөр байгааг олж илрүүлэхэд тусална.

Жендэр болон орхигдсон бүлгийн уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдлыг тооцоход шаардагдах мэдээллийг боловсролын яам, эрүүл мэндийн яам, статистикийн хороо, аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, сум, дүүргийн статистик хариуцсан мэргэжилтнүүд, харилцаа холбооны зохицуулах хорооноос насны бүлэг, хүйсийн ангилалтай гаргасан тоо мэдээллээс бүрдүүлнэ. Статистик мэдээллээс гадна тухайн орон нутгийн нийгмийн бүлгүүдийн дунд түүвэр судалгаа, чанарын судалгаа хийж орон нутаг, аймаг бүрийн онцлогийг харуулах мэдээллийг харуулна.

Улс, бүс, аймгийн дундажийг илэрхийлэхдээ тоо болон чанарын үзүүлэлтээр үр дүнг харуулж болно. Индексийг таслалаас хойш 3 оронгийн түвшинд гаргана. Индексийг тооцоход ашиглах шалгуур үзүүлэлтүүдийн бодит утга нь энэхүү аргачлалд заасан тоон утгуудаас давсан тохиолдолд шинэчлэн тогтоож, цаашид шинэчлэгдсэн утгуудыг индексийн тооцоонд ашиглана.

## 6. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Нийслэлийн хөгжлийн индекс тодорхойлох арга зүй, ҮСХ 2020
2. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, [www.1212.mn](http://www.1212.mn)
3. Гар утас, интернэт хэрэглэгч: тоо, бүтэц, ҮСХ, 2011